



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 09 өдөр

Дугаар A/34

Улаанбаатар хот

Тэмцээн зохион явуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 14.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Аврах анги-105 үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойг тохиолдуулан Нийслэлийн Онцгой байдлын газрын харьяа бүтцийн нэгжийн алба хаагчдын дунд 2019 оны аварга шалгаруулах 5 төрөлт (гар бөмбөг, усан сэлэлт, олс таталт, туухай өргөлт, ББЕХ-ын 224 тоот дасгал) тэмцээнийг 2019 оны 04 дүгээр сарын 30, 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсугай.
2. "Тэмцээний удирдамж"-ийг нэгдүгээр, тэмцээнд шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээн зохион явуулахад шаардагдах зардал 1.168.000 (нэг сая нэг зуун жаран найман мянга) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА *[Signature]* Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 04 дугээр сарын 09-ны өдрийн
Ажудугаар тушаалын нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2019 ОНЫ
АВАРГА ШАЛГАРУУЛАХ СПОРТЫН 5 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ
(ГАР БӨМБӨГ, УСАН СЭЛЭЛТ, ОЛС ТАТАЛТ,
ТУУХАЙ ӨРГӨЛТ ББЕХ-ЫН 224 ТООТ ДАСГАЛ)

Нэг: Зорилго

Нийслэлийн Аврах анги-105 үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойг тохиолдуулан Нийслэлийн Онцгой байдлын газрын алба хаагчдыг биеийн тамир, спортын нэгдсэн арга хэмжээнд оролцуулах, бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх, чөлөөт цагаа спортоор хичээллэж зөв боловсон өнгөрүүлэхэд оршино.

Хоёр: Тэмцээн явуулах журам, оролцох багууд.

Нийслэлийн Онцгой байдлын газар, ГХСАЗТ-ийн хамтарсан 1, нийслэлийн Аврах анги-105-ын 1, Дүүргийн Онцгой байдлын хэлтэс тус бүр 1, нийт 11 багийн тамирчид оролцено.

Уг тэмцээнд амжилттай оролцож амжилт гаргасан, цаашид амжилт гаргах боломжтой тамирчдыг 2019 оны 05 дугаар сарын 20-24-ний хооронд Ховд аймагт зохион байгуулагдах Онцгой байдлын албаны 2019 оны аварга шалгаруулах тэмцээнд Нийслэлийн Онцгой байдлын газрын шигшээ багт оролцуулна.

Тэмцээнд оролцох багууд өөр өөрийн ижил тогтолтын хувцастай байна.

Гурав. Тэмцээний төрөл

1. Гар бөмбөг:

Гар бөмбөгийн тэмцээнийг газар, хэлтэс 1 холимог баг оролцуулна.

Нэг багт 8 тамирчинтай байна. Тогтолтод 2 эмэгтэй тамирчин заавал тоглуулах ба эмэгтэй тамирчин тоглуулаагүй тохиолдолд тухайн багийг тэмцээнээс шууд хасна.
/офицер, ахлагч цолтой/

2. Усан сэлэлт:

Тэмцээн эрэгтэй, эмэгтэй ганцаарчилсан, багийн буухиа 4-н төрөл, Онцгой байдлын албаны мэргэжлийн 1 төрөл буюу усны гүнд нуусан биетийг олох нийт 5-н төрөлд явагдана. Нэг баг нь эрэгтэй 2, эмэгтэй 2, нийт 4 тамирчинтай холимог баг оролцено.

Эрэгтэй 1, эмэгтэй 1 тамирчин 50 метрт мэлхий сэлэлтээр,

Эрэгтэй 1, эмэгтэй 1 тамирчин 100 метрт өврөөр даллах сэлэлтээр,

Буухий уралдаанд 4x50метрт дараах 4 зайд уралдана. 50 метрийн өврөөр даллах эрэгтэй 1, эмэгтэй 1, 50 метрийн мэлхий сэлэлтээр эрэгтэй 1 эмэгтэй 1 тус тус уралдана.

Онцгой байдлын албаны мэргэжлийн төрөл "Усны гүнд нуусан биетийг олох хамгийн бага хугацаанд 5 метрийн гүнд нуусан биетийг олж гаргана. /1 тамирчин/

3. Олс таталт:

Багийн бүрэлдэхүүн 6 эрэгтэй, 2 эмэгтэй хүнээс бурдэх бөгөөд нийт багийн жин 600 кг-аас хэтрэхгүй байна. 2 таталтаар ялагчийг тодруулах ба тэнцсэн тохиолдолд гурав дахь таталтыг явуулна

4. Туухай өргөлт:

Нэг багд 1 эрэгтэй, 1 эмэгтэй нийт 2 тамирчин оролцоно. “Тэмцээнийг биеийн тамирын заавар” ЦБТЗ-18 номны 04 дүгээр бүлгийн 2.5. 22-р дасгал 2.6, 23-рт заасан дасгалаар тус тус явуулна.

Тухайны хүндийн жин 24 кг, 16 кг байна.

5. ББЕХ-ын 224 тоот дасгал:

Баг нь 12 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Онцгой байдлын албаны алба хаагчдын заавал эзэмших ББЕХ-ын 224 тоот дасгалыг хөгжмийн аянд нэгэн зэрэг гүйцэтгэлийн өндөр түвшинд дасгалын дэс дарааг зөв биелүүлэхээс гадна талбайд орох гарах жагсаалын хувиралтуудыг багийн тоглолтоор харуулна.

Тэмцээнд зөвхөн тухайн анги салбарын алба хаагчид оролцоно.

Дөрөв: Тэмцээнийг дүгнэх, зохион байгуулах хугацаа

Тэмцээнийг “Аврагч” спорт хорооны шүүгчид шүүн явуулна. Техникийн зөвлөгөөнийг 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 14.00 цагт НОБГ-ын Соёлын төвд зохион явуулна. Багууд оролцох тамирчдынхаа мэдүүлгийг техникийн зөвлөгөөн дээр өгнө. Мэдүүлэгт тухайн тамирчны спортын төрөл, цол зэргийг заавал тусгана.

Тэмцээн “Аврагч” Биеийн тамир спорт хорооны зааланд 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 08.30 цагаас эхэнэ.

Тэмцээнтэй холбоотой маргаан гарвал тухайн багийн ахлагч шүүгчид хандаж шийдвэрлүүлнэ.

Тав: Шагнал урамшуулал

I байр: Медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал,

II байр: Медаль, өргөмжлөл,

III байр: Медаль, өргөмжлөл спортын төрлүүдийн нийлбэр дүнгээр тэргүүн байр эзэлсэн багт цом хадгалуулна.

---Оо---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн
13 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2019 ОНЫ
АВАРГА ШАЛГАРУУЛАХ СПОРТЫН 5 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зарцуулах материал	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Гар бөмбөг 1-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
2	Гар бөмбөг 2-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
3	Гар бөмбөг 3-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
4	ББЕХ-ын 224 тоот дасгал 1-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
5	ББЕХ-ын 224 тоот дасгал 2-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
6	ББЕХ-ын 224 тоот дасгал 3-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
7	Усан сэлэлт 1-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
8	Усан сэлэлт 2-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
9	Усан сэлэлт 3-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
10	Туухай өргөлт 1-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
11	Туухай өргөлт 2-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
12	Туухай өргөлт 3-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
13	Олс таталт 1-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
14	Олс таталт 2-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
15	Олс таталт 3-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг		
16	Медаль	102	Ширхэг	9000	918,000
17	Шүүгч	5	Хүн	50000	250,000
Нийт					1,168,000

---оо---